



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар)-ын хөрөнгөд бүртгэлтэй 49,770,000.00 (дөчин есөн сая долоон зуун далан мянга) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Тоёото Лексус-470 маркийн 0053 ӨВА улсын дугаартай автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, Өвөрхангай аймгийн өмчид (“Онги ус суваг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга З.Балданням, Өвөрхангай аймгийн “Онги ус суваг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Б.Хоролсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137005093
15-r huraldaan.docx